



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/465

Мөрөн сум

Төсөвт өртгийн дээд хязгаар
тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоол, тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр барих, засварлах, шинэчлэх барилга байгууламжийн аймгийн зураг төсвийн сангаас санхүүжүүлэх инженер геологийн дүгнэлтийн зөвлөх үйлчилгээний дээд хязгаарыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. Төсөл арга хэмжээний зураг, төсөв инженер геологийн дүгнэлт боловсруулах зөвлөх үйлчилгээ нийлүүлэх гүйцэтгэгч сонгож гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсорогдог)-д даалгасугай.

3. Дээрх арга хэмжээний зураг төсвийн үнийг хавсралтад зааснаар санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа) нарт тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны
09 дүгээр сарын 11-ны өдрийн /11/ дугаартай
захирамжийн 1 дүгээр хавсралт

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН ДАХЬ “ЗУРАГ ТӨСВИЙН САН”-ААС
САНХҮҮЖҮҮЛЭХ ШИНЭЭР БАРИХ, ЗАСВАРЛАХ, ШИНЭЧЛЭХ, БАРИЛГА
БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨВ, ИНЖЕНЕР ГЕОЛОГИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ ЗӨВЛӨХ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨСӨВТ ӨРТГИЙН ДЭЭД ХЯЗГААР

№	Арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Тайлбар
1	9-р цэцэрлэг /Хөвсгөл, Мөрөн сум/	18,471,230	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна.
2	13-р цэцэрлэг /Хөвсгөл, Мөрөн сум/	19,850,994	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна.
3	Ус цаг уур орчны шинжилгээний төвийн лаборатор, конторын барилгын инженер геологийн дүгнэлт /Хөвсгөл, Мөрөн сум/	4,500,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна.
Нийт дүн		42,822,224	

_____оОо_____